



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/АА

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108-р тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД 81-16-20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XII хуралдааны XII/21 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/13 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвийн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийн хэмжээг нэмэгдүүлэх зураг төсөв боловсруулах ажлыг 56,500,000 (тавин зургаан сая таван зуу) төгрөгөөр “Аслаан” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Аслаан” ХХК (Ж.Банкрай)-д үүрэг болгосугай.

3. Аймгийн төвийн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийн хэмжээг нэмэгдүүлэх зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4. Дээрх ажлын санхүүжилтийг тухайн арга хэмжээний батлагдсан төсвөөс гэрээнд заасан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

6323019017